



ТӨВ АЙМГИЙН
СЭРГЭЛЭН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
257. ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2024 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 16

Эрдэнэ-Уул

Г Орон тооны бус зөвлөл байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: С.Зоригтбаатар (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)

Гишүүд: П.Гантуяа (Санхүүгийн албаны дарга)

С.Рэнцэн (Төрийн бус байгууллагын төлөөлөл)

С.Ганчимэг (Төрийн бус байгууллагын төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: М.Нандин-Эрдэнэ (Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, зээлийн эргэн төлөлтөд журмын дагуу хяналт тавьж тайлан мэдээг иргэдэд тавьж, иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргад хүргүүлж ажиллахыг Зөвлөлийн дарга (С.Зоригтбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА Т.БААСАНСҮРЭН

